



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/353

Чингис хот


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а", Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 9 дүгээр зүйлийн 9.1-9.9, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5, 34 дүгээр зүйлийн 34.2.2.1 дэх заалт, Засгийн газрын 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын үйлчилгээний хөлс, вакцин био бэлдмэл, оношлуур, эм урвалж, оношлогоо шинжилгээний техник, тоног төхөөрөмжийн үнэ, арга хэмжээний явц, гүйцэтгэлд хяналт шалгалт хийхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгагдсан 531437,1 (таван зуун гучин нэгэн сая дөрвөн зуун гучин долоон мянга нэг зуун мянган) төгрөгийг Мал эмнэлгийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т зөвшөөрсүгэй.

2. Мал эмнэлгийн арга хэмжээнд шаардлагатай вакцин, эм урвалж, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Н.Анхбаяр)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ